



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

᠑᠐᠐᠗ оны ᠐᠑ сарын 16 өдөр

Дугаар 10/᠕3

Номгон

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит X хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчин аялал жуулчлалын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2021 онд ашиглалтад орсон 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийн өртөгтэй "Виртуал студи"-ын барилгыг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2013 онд ашиглалтад орсон 111,249,000 (Зуун арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянган) төгрөгийн өртөг бүхий, 00-02БНА улсын дугаартай Land cruiser-200 маркийн автомашин, Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2013 онд ашиглалтад орсон 1,968,000 (нэг сая есөн зуун жаран найман мянга) төгрөгийн өртөг бүхий хайсыг Богд сумын Засаг даргын Тамгын газарт, Баянлиг сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2014 ашиглалтад орсон 1,955,444,097 (нэг тэрбум есөн зуун тавин таван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга ерэн долоон) төгрөгийн өртөгтэй 1017,3 м2 Соёлын төвийн хуучин барилгын 1,152,013,157 (нэг тэрбум нэг зуун тавин хоёр сая арван гурван мянга нэг зуун тавин долоон) төгрөгийн өртөгтэй хэсгийг Баянлиг сумын Засаг даргын Тамгын газарт, 709,48 м2 бүхий 803,430,940 (найман зуун гурван сая дөрвөн зуун гучин мянга есөн зуун дөчин) төгрөгийн өртөгтэй хэсгийг Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуульд, Галуут сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2018 онд ашиглалтад орсон 29,700,000 (хорин есөн сая долоон зуун мянган) төгрөгийн өртөгтэй 78-11БНА улсын дугаартай УАЗ-220695 маркийн автомашиныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

0121186

2.Шилжүүлсэн хөрөнгийг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг холбогдох байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Идэрмөнх)-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.

3.1.Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.2.Энэ тогтоолын хэрэгжилтийг 2022 оны 11 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ